



УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ ТӨХК

**“ЗУНЫ АЖЛЫН ГУТАЛ” НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендерийн нэр: ЗУНЫ АЖЛЫН ГУТАЛ

Тендерийн дугаар: ХАБАЭ-2019/04

Улаанбаатар хот

2019 он

ЦАХИМ ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2019 оны 04 дугаар сарын 23-ны өдөр

Тендерийн нэр: **“Зуны ажлын гутал” нийлүүлэх**

Тендерийн дугаар: **ХАБАЭ-2019/04**

“УБДС” ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос **“Зуны ажлын гутал”** нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000 /тавин мянган/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендерийг **2019 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн 11 цаг 00 минутаас** өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн 11 цаг 30 минутад** тендерийн нээлтийн өрөөнд нээнэ. /УБДС ТӨХК-н төв байрны 204 тоот/

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.
Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Захиалагчийн хаяг:

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Ф.Энгельсийн гудамж, “Улаанбаатар Дулааны сүлжээ” ТӨХК-ийн байр, 204 тоот өрөө, Худалдан авах ажиллагааны хэсэг

Утас: 75753047 +242

Цахим хаяг: www.tender.gov.mn

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<p>ТӨӨЗ-ны холбогдох заалт</p>	<p>Шалгуур үзүүлэлт</p>
<p>ТӨӨЗ 1.1</p>	<p>Захиалагч нь: "УБДС" ТӨХК</p>
<p>ТӨӨЗ 1.1</p>	<p>Тендерийн нэр дугаар: Зуны ажлын гутал ХАБАЭ-2019/04</p>
<p>ТӨӨЗ 1.1</p>	<ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн нэг жилийн /2018 /оны аудитлагдсан санхүүгийн тайлан. Сүүлийн 1 жилийн борлуулалтын орлого санал болгож буй үнийн дүнгийн 100%-иас багагүй байх 2. Сүүлийн нэг жил /2018 онд Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар ирүүлэх/ 3. Төсөвт өртөг: 39,957,500 төг Нэмэлт шаардлага 4. Компанийн дэлгэрэнгүй танилцуулга 5. Улсын бүртгэлийн гэрчилгээ 6. Үнийн саналыг маягтын дагуу ирүүлэх 7. Бараа нийлүүлэх хугацаа /Гэрээний дагуу / 8. Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт 9. ШШГЕГ-ын тодорхойлолт ирүүлнэ. 10. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолтыг Татварын ерөнхий газрын www.e-tax.mta.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолт авч ирүүлэх ба энэхүү тодорхойлолт нь, тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байна. Мөн татварын байгууллагаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын"-ын дагуу "татвар төлөлт, Сангийн яамны санхүүгийн тайлангийн сангаас санхүүгийн тайлангийн шаардлагатай мэдээллийг шалгана". 11. Нийлүүлэх барааны зураг, үйлдвэрлэгчийн каталогийн эх хувийг ирүүлнэ. Каталог дээрээс санал болгож буй барааг ялган тодруулж ирүүлнэ. Тендерийн хэл нь Монгол хэл тул гадаад хэл дээрх аливаа материалыг баталгаат орчуулгаар Монгол хэл рүү 12. Нийлүүлэгдэх барааг тендер хүлээж авах эцсийн хугацаанаас өмнө доорх хаягаар ирүүлэх. 14. Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан хүснэгтээр бэлтгэж баталгаажуулан ирүүлнэ. 15. Гэрээний үнээр, гэрээний хугацаанд хийж гүйцэтгэж, хүлээлгэж өгөхийг баталсан албан мэдэгдэл ирүүлнэ. 16. Тендерт оролцогч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр мэдээлнэ. 17. Зуны ажлын гуталны хэмжээг хүн тус бүрээр гаргаж, гэрээ байгуулсаны дараа өгнө. 18. Засварчин, үйлчилгээний ажилтаны гутлын загвар, өнгө, хийцийн сонголтыг тохирч батална. 19. Хөнгөн жинтэй, хөлд эвтэйхэн, өндөр температураас хамгаалсан байна. 20. Халуунд халууцахгүй, хүйтэнд хайрахгүй 21. Ажлын гуталны ул нь шахмал, салдаггүй байна.

	<p>22. Гутлын гадар бүрэн боловсруулсан зөөлөн , үхрийн шир байна.</p> <p>23. Засварчины гутал урт түрийтэй, үдээсгүй, түрийний өндөр 26см-ээс дээш хэмжээтэй байна. Давхар оёдолтой байна.</p> <p>24. Зуузай хатуулгатай, эдэлгээ даах бат бөх чанартай, хөлийн чөлөөтэй байдлыг бүрэн хангасан</p> <p>25. Гутлын дотор тал агаарын солилцоог бүрэн нэвтрүүлэх, хөлсийг түргэн шингээж гадагшлуулах, улавч нь шир байна.</p> <p>26. Хуруу, өлмий, шагайны төмөр хамгаалалттай, цахилгаанждаггүй байх ба улнаас хадаас төмөр хатгахаас хамгаалсан төмөр давхаргатай байна.</p> <p>27. Зуны ажлын гутал нийлүүлэх компани нь өөрийн гэсэн үйлдвэрлэлийн ажлын байртай / ажлын байрны фото зургийг ирүүлнэ / , оёдол хийх иж бүрэн тоног төхөөрөмжтэй / тоноглолын паспорт сертификат, фото зургийг ирүүлнэ/ байх</p> <p>28. Орон тооны мэргэжлийн загвар зохион бүтээгч, стилист, мэргэжлийн багадаа 10-н оёдолчинтой байх / мэргэжилтэй ажилчдын тодорхойлолтыг ирүүлнэ /</p> <p>29. 250 хүний зуны ажлын гутлыг ажлын 20 хоногт хийж гүйцэтгэх хүчин чадалтай байх / Энэ тухай албан бичгээр мэдэгдэл ирүүлнэ. /</p> <p>30. Хөдөлмөр хамгааллын гутал, хувцас нийлүүлж байсан ажлын сайн туршлагатай байх . Үүнд: Сүүлийн 5-н жилийн аль нэгэнд хийж гүйцэтгэсэн ажлын гэрээ, гэрээ дүгнэсэн актын хуулбарыг ирүүлнэ.</p> <p>31. Зуны ажлын гутал, үйлчилгээний ажилтаны гуталны загвар төрөл тус бүрт дээж ирүүлж, сонголтыг тохирох үүрэгтэй. / өнгө загварыг тохирно /</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Ф.Энгельсийн гудамж, “Улаанбаатар Дулааны сүлжээ” ТӨХК-ийн байр, 204 тоот өрөө</p> <p>Огноо: 2019 оны 04-р сарын 30-ны өдөр Цаг: 11 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Ф.Энгельсийн гудамж, “Улаанбаатар Дулааны сүлжээ” ТӨХК-ийн байр, 204 тоот өрөө</p> <p>Огноо: 2019 оны 04 дугаар сарын 30-ны өдөр Цаг: 11 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 3.1.д	ТӨӨЗ-ны 3.1-д заасан материалаас гадна ирүүлэх шаардлагатай материал байгаа тохиолдолд жагсааж бичнэ.
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй
ТӨӨЗ 18.1 (д)	Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: Шаардлагатай

Гурав.

1. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Тодорхойлолт	№	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа			
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа	
1	2	3	4	5	6	7	8	9
1 Зуны ажлын гутал	Зуны ажлын гутал загвар № 1	320	хос	“УБДС” ТӨХК-н байр	Гэрээ байгуулснаас хойш 14 хоног	Гэрээ байгуулснаас хойш 14 хоног		
	Үйлчилгээний ажилтанд загвар № 2	15	Хос					

2019 онд "УБДС" ХК-ийн ажиллагсдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангахад олгох барааны тодорхойлолт

- Ерөнхий шаардлага**

БАГЦ	№	Аюулгүй ажиллагааг хангах барааны нэрс	Хэмжих нэгж	Тоо
1	1	Зуны ажлын гутал загвар № 1	хос	320
	2	Үйлчилгээний ажилтанд загвар № 2	хос	15

- Зуны ажлын гутал**

- Зуны ажлын гуталны хэмжээг хүн тус бүрээр гаргаж, гэрээ байгуулсаны дараа өгнө.
- Засварчин, үйлчилгээний ажилтаны гутлын загвар, өнгө, хийцийн сонголтыг тохирч батална.
- Хөнгөн жинтэй, хөлд эвтэйхэн, өндөр температураас хамгаалсан байна.
- Халуунд халууцахгүй, хүйтэнд хайрахгүй
- Ажлын гуталны ул нь шахмал, салдаггүй байна.
- Ус тос нэвтрэхгүй, гутлын дотор нь чийг татахгүй, дотрын зориулалттай арьсаар хийнэ.
- Гутлын гадар бүрэн боловсруулсан зөөлөн , үхрийн шир байна.
- Засварчины гутал урт түрийтэй, үдээсгүй, түрийний өндөр 26см-ээс дээш хэмжээтэй байна. Давхар оёдолтой байна.
- Зуузай хатуулгатай, эдэлгээ даах бат бөх чанартай, хөлийн чөлөөтэй байдлыг бүрэн хангасан
- Гутлын дотор тал агаарын солилцоог бүрэн нэвтрүүлэх, хөлсийг түргэн шингээж гадагшлуулах, улавч нь шир байна.
- Хуруу, өлмий, шагайны төмөр хамгаалалттай, цахилгаанждаггүй байх ба улнаас хадаас төмөр хатгахаас хамгаалсан төмөр давхаргатай байна.

- Бусад шаардлагууд**

- Зуны ажлын гутал нийлүүлэх компани нь өөрийн гэсэн үйлдвэрлэлийн ажлын байртай / ажлын байрны фото зургийг ирүүлнэ / , оёдол хийх иж бүрэн тоног төхөөрөмжтэй / тоноглолын паспорт сертификат, фото зургийг ирүүлнэ/ байх
- Орон тооны мэргэжлийн загвар зохион бүтээгч, стилист, мэргэжлийн багадаа 10-н оёдолчинтой байх / мэргэжилтэй ажилчдын тодорхойлолтыг ирүүлнэ /
- 250 хүний зуны ажлын гутлыг ажлын 20 хоногт хийж гүйцэтгэх хүчин чадалтай байх / Энэ тухай албан бичгээр мэдэгдэл ирүүлнэ. /
- Хөдөлмөр хамгааллын гутал, хувцас нийлүүлж байсан ажлын сайн туршлагатай байх . Үүнд: Сүүлийн 5-н жилийн аль нэгэнд хийж гүйцэтгэсэн ажлын гэрээ, гэрээ дүгнэсэн актын хуулбарыг ирүүлнэ.
- Зуны ажлын гутал, үйлчилгээний ажилтаны гуталны загвар төрөл тус бүрт дээж ирүүлж, сонголтыг тохирох үүрэгтэй. / өнгө загварыг тохирно /

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Саранжав танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорх ойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фа кс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ажлын 90] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |

- 10. Үүргээ биелүүлээг үй-гээс гэрээг цуцлах**
- 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
- 11. Маргааныг шийдвэрлэх**
- 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- Чанарын баталгаа, баталгаат засварын хугацаа 6 сар байна. Баталгаат засварын хугацааны барьцаа хөрөнгө гэрээний үнийн 5% байна.
- 4. Төлбөр (ГЕН – 7)**
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийг барааг хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн протокол болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн ажлын 90 хоногын дотор төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹**
- 2.1. Алданги оногдуулах хувь: **0,1%**.
Алдангийн нийт дүн: Гэрээний үнийн дүнгийн **10%-иас хэтрэхгүй**.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ²

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _ оны _ сарын _ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _ нэр төрлийн барааг _ оны _ дугаар сарын _ -наас _ оны _ дугаар сарын _ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.